



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/37

Хэрлэн сум

Хогийн цэгийг цэгцлэх, хашаажуулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих Хэнтий аймгийн Баянхутаг суманд Хогийн цэгийг цэгцлэх, хашаажуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Ганчимэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Ц.Мягмар-Ариунаа


Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Ц.Бат-Эрдэнэ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг Ажлын хэсгийн дарга (Ц.Ганчимэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ